



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/964

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 06 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын Ерөнхий газар, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран 2023 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Стратегийн команд штабын сургуулийг зохион байгуулахтай холбогдуулан сургуульд оролцох бэлтгэл ажлыг хангасугай.
2. Сургуульд оролцох бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, нэрсийг хавсралтаар баталсугай.
3. Сургуульд оролцох бэлтгэл ажлыг бүрэн хангаж, амжилттай оролцохыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100707

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дугаар сарын 09-ны өдрийн 04 дугаар
захирамжийн 04 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Анхбаяр (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга

Аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн
хэлтсийн дарга

Аймгийн Онцгой байдлын газрын дарга

Аймгийн Цагдаагийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын
дарга

Аймгийн Тагнуулын хэлтсийн дарга

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
дарга

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Мал эмнэлгийн газрын дарга

Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга

“Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын дарга

Дундговь Мэдээлэл холбооны сүлжээ салбарын дарга

Аймгийн Автотээврийн төвийн дарга

Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Н.Түвшинжаргал (аймгийн Засаг даргын Тамгын
газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Л.Дорждэрэм (Онцгой байдлын газрын Орлогч
даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч)